

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Г.Баярсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд төрөөс гэр бүл, эцэг эх, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нөхцөл, журам, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, хүүхдийг гэр бүлдээ асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулахаар тусгасан байна.

Төсөл санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар гэрлэлтээ бүртгүүлэх, гэр бүлийн болон гэрлэлтийн, хамтран амьдрах гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлснээр хүүхдийн эрх ашгийг хангах механизм бүрдэж, гэр бүлийн зөвлөгөө үзүүлэх төрийн бус байгууллагуудын чадавхи бэхжиж, хүүхдийн тэтгэлгийг төлүүлэх нөхцөл хангагдаж, эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага нэмэгдэж, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг байгуулснаар төрийн үйлчилгээг гэр бүлд хүргэх нөхцөл бүрдэх зэрэг ач холбогдолтой гэж үзжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг 15.1 дэх заалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлтэй уялдуулах, зөрчилтэй заалтуудыг өөрчлөн найруулах, өрх толгойлсон эмэгтэйчүүд болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн шийдвэрийн дагуу хүүхдийн тэтгэлгийг бүрэн нөхөн төлүүлэх, хамтран амьдрагчийг хуульчлан оруулж өгөх, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа өрх толгойлсон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, гэр бүлийг бат бөх байлгах, хүүхдийн тэтгэлгийг олгох цаг хугацааны хүчин зүйлсийг тооцож үзэх, тэтгэлэг төлүүлэх бусад орны туршлагыг судлах, тэтгэлгийн сан байгуулах, цаг хугацаанд нь тэтгэлэг олгогдоогүйгээс гэр бүл ядуурах, хүүхэд гэмт хэрэгт өртөх, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл хуулийн төслийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлтэй уялдуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой олон тохиолдол гарч байгааг онцлоод гэр бүлийн гишүүдийн эдийн засгийн тэгш байдлыг хангах, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хэрхэн уялдуулах, хуулийн төслийг бусад Байнгын хороогоор хэлэлцүүлэх, хуулийн шинэ нэр томъёог зөв тодорхойлох, хамтран амьдрахыг хуульчлах нь эргээд гэр бүлийн харилцаанд сөрөг үр дагавар бий болгох эсэхэд анхаарахыг сануулж, өөрөө хуулийн төслийн ажлын хэсгийн

ахлагчаар ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл гэр бүлийн шинэ харилцааг зохицуулахыг дэмжээд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зарим зүйл, заалтад анхаарлаа хандуулах, гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлахыг шаардах эрхгүй байх нь хэр оновчтой болох, сайн дурын үндсэн дээр асран хамгаалагчаас татгалзах боломжит хувилбарыг гаргах, гэрлэгчдийн ёс зүйн хариуцлагыг чангатгах, хуулийн төслийг найруулгын хувьд чамбайруулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь нийгмийн бүхий л харилцааг зохицуулахыг оролдох нь хэр оновчтой болох, ёс зүй, үндэсний уламжлалт гэр бүлийн харилцаа, эд хөрөнгийн маргааны зохицуулалтыг тусгах, гэрлэгчдийн харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг саналуудыг тус тус гаргалаа.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ